



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1, “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит “Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” ҮЦК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хавсралт ёсоор чөлөөлж, томилсугай.

2. Томилогдсон гишүүдэд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 118.
дугаар тогтоолын хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС
ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ГИШҮҮДИЙН НЭРС**

№	Байгууллагын нэрс	Чөлөөлөх гишүүний нэр	Томилох гишүүдийн нэрс	Эрхэлж буй ажил, албан тушаал
1	Нийслэлийн өмчит "Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент" ҮЦК ХХК	Б. Үүрцайхбаатар (хараат бус)	Д.Хүрэлбаатар	Хараат бус
			Т.Баасанжав	Хараат бус
			Э.Баясгалан	Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн
			В.Баттулга	Нийслэлийн ЗДТГ-ын Хууль, тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын Ахлах мэргэжилтэн